



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ДАШЗЭГВИЙН АМАРБАЯСГАЛАН
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2024.12.25 № 3Г-1/170

танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр хэлэлцүүлэхээр шийдвэрлэсний дагуу өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэхийг хүсье.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

000244008437



УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Б.БААСАНДОРЖ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2024.12.25 № ХЭГ/2684

танай _____-ны № _____-т

**Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай**

Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлохыг хүсье.

Хавсралт ¹⁴ хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Н.УЧРАЛ

000245026265



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2024.12.25 № 1/2563

танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Н.УЧРАЛ ТАНАА

Үндэсний баялгийн сангийн тухай хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
болон дагалдуулан боловсруулсан хуулийн төсөл нь
Хууль тогтоомжийн тухай хуулийн 19¹ дүгээр зүйлийн
19^{1.1} дэх хэсэгт зааснаар Хууль тогтоомжийн тухай
хуульд заасан шаардлагыг хангасан байна.



О.АЛТАНГЭРЭЛ

1516056
А3.файл.2024



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: <http://www.mof.gov.mn>

2024.12.25 № 01/10646

танай 2024.12.25-ны № ХЭГ/2683 -Т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.УЧРАЛ ТАНАА

Танаас ирүүлсэн 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн зөвшөөрөл хүсэх тухай ХЭГ/2683 тоот албан бичигтэй танилцаад Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагалдах бусад хуулийн төслийн хамт Хууль тогтоомжийн тухай хуулийн 20.7-д заасны дагуу Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг үүгээр олгож байна.

Хүндэтгэсэн,



Б.ЖАВХЛАН

9761003567



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2024. 12. 25

№

1/2564

танай

-ны №

-т

**МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Н.УЧРАЛ ТАНАА**

Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдуулан боловсруулсан хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасныг үндэслэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



О.АЛТАНГЭРЭЛ


151605/07
Аб.файл.2024

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС


Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны 46 дугаар тэмдэглэлд:

“2.ХЭЛЭЛЦСЭН нь: Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хуулийн төслийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



**ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр “Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээх, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно” гэж байгалийн баялаг, түүний дотор газрын хэвлийн баялгийг ашиглах суурь зарчмыг баталгаажуулсан билээ.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-ийн 1.1.1-д “байгалийн баялаг ард түмний мэдэлд, төрийн нийтийн өмч байх эрх зүйн орчныг бүрдүүлэхдээ энэхүү баялгийг төр өмчлөх, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашигласны үр өгөөж /татвар, ашиг гэх мэт/-ийн дийлэнх нь буюу тавиас дээш хувь нь Монголын ард түмэнд ногдох, шаардлагатай бол иргэдийн саналыг харгалзан Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэх зарчмыг хуульчлах”-аар заасан.

Энэхүү зорилтын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурлаас Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр баталсан бөгөөд тус хуульд Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сан болох Хөгжлийн сан, Ирээдүйн өв сан, Хуримтлалын сангийн хөрөнгийн эх үүсвэр, зориулалт, хуваарилалт, хөрөнгийн удирдлагын талаар хуульчлан тогтоосон. Тодруулбал, Ирээдүй өв санд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс Төсвийн тогтворжуулалтын болон Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд хуваарилаад, үлдэх хэсгийн 65 хувийг, Хуримтлалын санд орлого төвлөрүүлэгч хуулийн этгээдийн нэгдэлд хамаарах буюу уул уурхайн олборлолт, ашигт малтмал боловсруулах салбарын бүх төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн нийт хувьцааны 34 хүртэлх хувьцаанд ногдох ногдол ашгийг төвлөрүүлэн газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд тэгш, шударга хүртээх ерөнхий зохицуулалтыг тусгасан.

2024 оны байдлаар Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сан болох Ирээдүйн өв санд 3,972.7 тэрбум төгрөг, Хуримтлалын санд 495 тэрбум төгрөгийн хөрөнгө төвлөрүүлээд байна.

Гэтэл тус сангуудийн эх үүсвэрийг Ашигт малтмалын тухай хууль болон Цөмийн энергийн тухай хуульд зөрчилтэй байдлаар тусгасан нь Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11.1-д заасан Баялгийн санд төвлөрүүлэх эх үүсвэрийг бууруулахаас гадна Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2-т заасан “газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээх” зарчимд нийцэхгүй байна.

Тухайлбал, Ашигт малтмалын тухай хуулийн 47².2, 47².3-т стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулж болохоор зохицуулж, тусгай төлбөрийн хувь, хэмжээг тухайн ордын онцлогоос хамаарч 5 хувиас хэтрэхээргүй байх хязгаарыг баримтлан Засгийн газар тогтоохоор заасан.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулиар Хуримтлалын санд орлого төвлөрүүлэгч хуулийн этгээдийн нэгдэлд хамаарах уул уурхайн олборлолт, ашигт малтмал боловсруулах салбарын бүх төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн нийт хувьцааны 34 хүртэлх хувьцаанд ногдох ногдол ашгийг төвлөрүүлдэг бөгөөд тус сангийн хөрөнгө нь иргэдийн боловсрол, эрүүл мэнд, орон сууцны хэрэгцээнд зарцуулахаар зохицуулсан.

Харин Ашигт малтмалын тухай хуулийн 47².1-д стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийг улсын төсөвт төлөхөөр заасан нь зөрчил үүсгэж байна.

Түүнчлэн, Ашигт малтмалын тухай хуулийн болон Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр болон дээр дурдсан бусад хувилбараар орлуулах тохиолдолд орлогыг Үндэсний баялгийн сангийн аль төрөлжсөн санд төвлөрүүлэх талаар зохицуулалт тодорхойгүй үлджээ.

Эдгээр хуулийн зөрчил, хийдэлтэй байдал нь Үндэсний баялгийн сангийн Хуримтлалын санд “төрийн эзэмшилд ногдох ногдол ашиг” хэлбэрээр төвлөрөх байсан эх үүсвэр “ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр” хэлбэрээр бусад төрөлжсөн санд болон улсын төсөвт төвлөрүүлж, хуулийн зорилгоос өөрөөр хуваарилагдах нөхцөлийг үүсгэж, Хуримтлалын сангийн иргэний эрүүл мэнд, боловсрол, орон сууцны зориулалтаар дэмжлэг үзүүлэх эх үүсвэрийг буруулах сөрөг үр дагаварт хүргэхээр байна.

Иймд Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн зорилго, үзэл санааг хадгалах, хууль хоорондын уялдааг хангаж, хийдэл, зөрчлийг арилгах, дээр дурдсан орлогыг аль төрөлжсөн санд төвлөрүүлэхийг тодорхой болгох хууль зүйн шаардлага үүсээд байна.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөлд Ашигт малтмалын тухай хуулийн 47².1-д заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр болон Цөмийн энергийн тухай хуулийн 20¹.5-д заасан цацраг идэвхт ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр, Цөмийн энергийн тухай хуулийн 5.5-д заасан төрийн

эзэмшлийн хувь хэмжээг бүтээгдэхүүн хуваах, төрийн эзэмшлийн хувьцааны төрлийг өөрчлөх зэрэг хувилбараар орлуулснаас бий болсон татварын бус орлогыг Хуримтлалын санд төвлөрүүлэхээр нэмж тусгалаа.

Тус хуулийн төсөл нь 3 зүйлтэй байх бөгөөд 1, 3 дугаар зүйлд Хуримтлалын санд төвлөрүүлэх хөрөнгийн эх үүсвэрт дээр дурдсан орлогыг хамруулахаар зохицуулж, 2 дугаар зүйлд тус орлогыг Хуримтлалын сангийн бусад орлогоос ялган төвлөрүүлэх журмыг тодруулан зохицуулна.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг ашиг малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр болон бусад хувилбараар орлуулснаас бий болсон орлогыг Ирээдүйн өв санд биш, хуулийн зорилгын дагуу Хуримтлалын санд төвлөрүүлж, иргэдэд эрүүл мэнд, боловсрол, орон сууцны зориулалтаар дэмжлэг үзүүлэх эх үүсвэрийг бодитой нэмэгдүүлэх боломжтой болно.

Ингэснээр байгалийн баялгаас олсон орлогыг Хуримтлалын сангаар дамжуулан иргэдэд тэгш, шударга хүртээх Монгол Улсын Үндсэн хуулийн суурь зарчим хангагдах эрх зүйн нөхцөл бүрдэнэ.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Хуулийн төслийн зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцэх бөгөөд Монгол Улсын нэгдэн орсон олон Улсын гэрээ болон бусад хууль тогтоомжтой зөрчилдөхгүй.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулах бөгөөд дагалдуулан Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

Энэхүү асуудал нь Монголын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.1.3-т заасан эдийн засгийн аюулгүй байдлыг хангахад чиглэх тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д заасны дагуу яаралтай горимоор хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй байна.

---o0o---

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Үндэсний баялгийн сангийн тухай хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон
дагалдах бусад хуулийн төслийн талаар

Монгол Улсын Үндсэн хуульд

19 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр баталгаажуулсан зарчимд нийцүүлэн Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын Их Хурлаас Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр баталсан.

Тус хуульд Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сан болох Хөгжлийн сан, Ирээдүйн өв сан, Хуримтлалын сангийн хөрөнгийн эх үүсвэр, зориулалт, хуваарилалт, хөрөнгийн удирдлагын талаар хуульчлан тогтоосон.

Тодруулбал, Ирээдүй өв санд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс Төсвийн тогтворжуулалтын болон Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд хуваарилаад, үлдэх хэсгийн 65 хувийг, Хуримтлалын санд орлого төвлөрүүлэгч хуулийн этгээдийн нэгдэлд хамаарах буюу уул уурхайн олборлолт, ашигт малтмал боловсруулах салбарын бүх төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн нийт хувьцааны 34 хүртэлх хувьцаанд ногдох ногдол ашгийг төвлөрүүлэн газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд тэгш, шударга хүртээх зохицуулалтыг тусгасан.

Тус сангуудийн эх үүсвэрийг Ашигт малтмалын тухай болон Цөмийн энергийн тухай хуульд зөрчилтэй байдлаар тусгасан нь Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11.1-д заасан Баялгийн санд төвлөрүүлэх эх үүсвэрийг бууруулахаар байгаа төдийгүй Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2-т заасан “газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээх” зарчимд нийцэхгүй байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 47^{2.2}, 47^{2.3}-т стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулж болохоор зохицуулж, тусгай төлбөрийн хувь, хэмжээг тухайн ордын онцлогоос хамаарч 5 хувиас хэтрэхээргүй байх хязгаарыг баримтлан Засгийн газар тогтоохоор заасан.

Харин Цөмийн энергийн тухай хуульд 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр цацраг идэвхт ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах, бүтээгдэхүүн хуваах, төрийн эзэмшлийн хувьцааны төрлийг өөрчлөх, эдгээрийг хослуулах зэрэг үр өгөөжийн дийлэнх нь Монгол Улсад ногдох хувилбарыг харгалзан Засгийн газрын мэдүүлснээр Улсын Их Хурал өөрөөр тогтоож болохоор зөрүүтэй зохицуулжээ.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулиар Хуримтлалын санд орлого төвлөрүүлэгч хуулийн этгээдийн нэгдэлд хамаарах уул уурхайн олборлолт, ашигт малтмал боловсруулах салбарын бүх төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн нийт хувьцааны 34 хүртэлх хувьцаанд ногдох ногдол ашгийг төвлөрүүлдэг бөгөөд тус сангийн хөрөнгө нь иргэдийн боловсрол, эрүүл мэнд, орон сууцны хэрэгцээнд зарцуулахаар зохицуулсан.

Гэтэл Ашигт малтмалын тухай хуулийн 47².1-д стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийг улсын төсөвт төлөхөөр заасан нь зөрчил үүсгэж байна.

Түүнчлэн, Ашигт малтмалын тухай хуулийн болон Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр болон бусад хувилбараар орлуулах тохиолдолд орлогыг Үндэсний баялгийн сангийн аль төрөлжсөн санд төвлөрүүлэх талаар зохицуулалт тодорхойгүй үлджээ.

Ийнхүү хууль хоорондын зөрчил, хийдэлтэй байдал нь Хуримтлалын санд “төрийн эзэмшилд ногдох ногдол ашиг” хэлбэрээр төвлөрөх байсан эх үүсвэрийг “ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр” хэлбэрээр бусад төрөлжсөн санд буюу анхны зорилгоос өөрөөр хуваарилах нөхцөлийг үүсгэж, иргэний эрүүл мэнд, боловсрол, орон сууцны зориулалтаар дэмжлэг үзүүлэх эх үүсвэрийг бууруулах сөрөг үр дагаварт хүргэхээр байна.

Иймд хууль хоорондын уялдааг хангаж, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөлд Ашигт малтмалын тухай хуулийн 47².1-д заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр болон Цөмийн энергийн тухай хуулийн 20¹.5-д заасан цацраг идэвхт ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр, Цөмийн энергийн тухай хуулийн 5.5-д заасан төрийн эзэмшлийн хувь хэмжээг бүтээгдэхүүн хуваах, төрийн эзэмшлийн хувьцааны төрлийг өөрчлөх зэрэг хувилбараар орлуулснаас бий болсон татварын бус орлогыг Хуримтлалын санд төвлөрүүлэхээр нэмж тусгалаа.

Мөн тус хуулийн төслийг дагалдуулан Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Ашигт малтмалын тухай хуулийн 47².1-д стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийг улсын төсөвт төлөхөөр заасныг өөрчилж, Хуримтлалын санд төвлөрүүлэхээр зохицуулсан. Мөн хуулийн 47².3-т “стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээ нь тухайн ордын онцлогоос хамаарч 5 хувиас хэтрэхээргүй байх”-аар заасныг Цөмийн энергийн тухай хуультай уялдуулан “Засгийн газрын өргөн мэдүүснээр Улсын Их Хурал тогтоох” зарчмыг тусгасан.

Ийнхүү хуульд тусгайлан зохицуулаагүй орхигдуулсан хийдэл, хууль хоорондын зөрчлийг арилгаснаар байгалийн баялгаас олсон орлогыг Хуримтлалын сангаар дамжуулан иргэдэд тэгш, шударга хүртээх Монгол Улсын Үндсэн хуулийн суурь зарчим хангагдах боломж бүрдэнэ.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулсан.

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон дагалдах бусад хуулийн төслийн талаар

Монгол Улсын Их Хурлаас Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр баталсан. Тус хуульд Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сан болох Хөгжлийн сан, Ирээдүйн өв сан, Хуримтлалын сангийн хөрөнгийн эх үүсвэр, зориулалт, хуваарилалт, хөрөнгийн удирдлагын талаар хуульчлан тогтоосон.

Дээрх сангуудийн эх үүсвэрийг Ашигт малтмалын тухай болон Цөмийн энергийн тухай хуульд зөрчилтэй байдлаар тусгасан нь Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11.1-д заасан Баялгийн санд төвлөрүүлэх эх үүсвэрийг бууруулахаас гадна Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2-т заасан “газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээх” зарчимд нийцэхгүй байна.

Түүнчлэн, Ашигт малтмалын тухай хуульд ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг Засгийн газар тогтоохоор заасан бол Цөмийн энергийн тухай хуульд Монгол Улсад ногдох хувилбарыг харгалзан Засгийн газрын мэдүүлснээр Улсын Их Хурал тогтоож болохоор зөрүүтэй байдлаар зохицуулжээ.

Мөн стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр болон бусад хувилбараар орлуулах тохиолдолд орлогыг Үндэсний баялгийн сангийн аль төрөлжсөн санд төвлөрүүлэх талаар зохицуулалт тодорхойгүй үлджээ.

Ийнхүү хууль хоорондын зөрчил, хийдэлтэй байдал нь “төрийн эзэмшилд ногдох ногдол ашиг” хэлбэрээр Хуримтлалын санд төвлөрөх байсан эх үүсвэрийг “ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр” хэлбэрээр бусад төрөлжсөн санд, хуулийн зорилгоос өөрөөр хуваарилах нөхцөлийг үүсгэж, иргэнд эрүүл мэнд, боловсрол, орон сууцны зориулалтаар дэмжлэг үзүүлэх эх үүсвэрийг буруулах сөрөг үр дагаварт хүргэхээр байна.

Иймд хууль хоорондын уялдааг хангаж, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөлд ашигт малтмалын орд эзэмшигч хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувь, хэмжээг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр болон бүтээгдэхүүн хуваах, төрийн эзэмшлийн хувьцааны төрлийг өөрчлөх зэрэг хувилбараар орлуулах тохиолдолд орлогыг Хуримтлалын сангийн эх үүсвэрт төвлөрүүлэх эрх зүйн зохицуулалтыг тусгасан.

Мөн тус хуулийн төслийг дагалдуулан Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан.

Хуулийн төсөл батлагдснаар хуулийн хийдэл, зөрчил арилж, байгалийн баялгаас олсон орлогыг Хуримтлалын сангаар дамжуулан иргэдэд тэгш, шударга хүртээх Монгол Улсын Үндсэн хуулийн суурь зарчим хангагдах боломж бүрдэнэ.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 он ... дугаар сарын
... өдөр

Улаанбаатар
хот

ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд доор дурдсан агуулга бүхий 11.1.2.в, 11.1.2.г дэд заалтыг тус тус нэмсүгэй:

“11.1.2.в. Ашигт малтмалын тухай хуулийн 47².1-д заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр болон Цөмийн энергийн тухай хуулийн 20¹.5-д заасан цацраг идэвхт ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр;

11.1.2.г. Цөмийн энергийн тухай хуулийн 5.5-д заасан төрийн эзэмшлийн хувь хэмжээг бүтээгдэхүүн хуваах, төрийн эзэмшлийн хувьцааны төрлийг өөрчлөх зэрэг хувилбараар орлуулснаас бий болсон татварын бус орлого.”

2 дугаар зүйл. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2.а, 11.1.2.б дэх дэд заалтын “уул уурхайн олборлолт” гэсний өмнө “энэ хуулийн 12.9-д заасны дагуу төвлөрүүлсэн ногдол ашгаас” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“11.1.2. Хуримтлалын сан дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 он ... дугаар сарын
... өдөр

Улаанбаатар
хот

АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 47² дугаар зүйлийн 47².2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“47².2.Энэ хуулийн 5.3, 5.4, 5.5-д заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын энэ хуулийн 47².1-д заасан ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг тухайн ордын онцлогоос хамаарч Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно.”

2 дугаар зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 47² дугаар зүйлийн 47².1 дэх хэсгийн “тооцож улсын төсөвт төлнө.” гэснийг “тооцно.” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 47² дугаар зүйлийн 47².3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг